



**УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ 2023 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024 он

АГУУЛГА

1. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН	2
1.1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ 2	
1.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	4
1.3. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	5
1.4. САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	7
2. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	8
3. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ	18
3.1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	18
3.2. ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ	19
3.3. ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ.....	19
3.4. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ	19
4. БУСАД ТАЙЛАН	20
4.1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ	20
4.2. ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ	22
4.3. УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	23
4.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	25
5. ДҮГНЭЛТ.....	27
6. ЗӨВЛӨМЖ.....	29
7. ХАВСРАЛТ.....	30

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” зэргийг тус тус баримтлан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны байгууллагын үйл ажиллагаанд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны үйл ажиллагаа, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний нэгтгэсэн тайланд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, Салбарын нийгэм, эдийн засгийн үзүүлэлт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн биелэлт, Байгууллагын ил тод байдлын үнэлгээнд тулгуурлан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 3 багц, 7 үзүүлэлтээр дүгнэв.

Түүнчлэн Аймгийн засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт, Гадаадын зээл тусламжийн санхүүжилтээр салбарт хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт, Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт болон бусад тайлангуудыг оруулан тайлагнав.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2023 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад ерөнхий үнэлгээ **87.4%** буюу **4.4** оноотой байна.

1. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

1.1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2023 оны жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт **170 шийдвэрийн 336 зүйл, заалтыг** салбар чиглэлээр ангилж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **88.9** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

Нийт 170 шийдвэрийн 336 зүйл, заалтаас 38 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй бөгөөд хэрэгжилтийг дүгнэсэн 298 зүйл, заалтын 205 зүйл, заалт “бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй, 80 зүйл, заалт “хэрэгжих шатанд” 70 хувийн биелэлттэй, 13 зүйл, заалт “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй байна.

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭ /Хууль тогтоомжийн төрлөөр/**

	Бүгд	Монгол Улсын хууль	Улсын Их Хурлын тогтоол	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	
Хяналтад авагдсан шийдвэрийн тоо	170	10	17	20	2	52	61	4	2	2	-	
Заалтын тоо	336	20	44	64	2	66	128	8	2	2	-	
Үүнээс	"бүрэн хэрэгжсэн" 100%	205	14	15	33	2	46	86	6	2	1	-
	"хэрэгжих шатанд" 70.0%	80	2	21	16	-	9	30	1	-	1	-
	"хэрэгжилт хангалтгүй" 30.0%	13	1	2	2	-	3	5	-	-	-	-
	"хэрэгжээгүй" 0%	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Үнэлгээ өгөөгүй	36	3	6	13	-	8	7	1	-	-	-
	Үнэлгээ	88.9	92.4	79.7	87.8	100.0	91.7	89.7	95.7	100.0	85.0	-

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 10 хуулийн 20 заалтын хэрэгжилт – 92.4%
- Улсын Их Хурлын 17 тогтоолын 44 заалтын хэрэгжилт – 79.7%
- УИХ-ын Байнгын хорооны 20 тогтоол 64 заалтын хэрэгжилт – 87.8%
- Ерөнхийлөгчийн 2 зарлиг 2 заалтыг хэрэгжилт – 100%
- Засгийн газрын 52 тогтоолын 66 заалтын хэрэгжилт – 91.7%;
- Засгийн газрын хуралдааны 61 тэмдэглэлийн 128 заалтын хэрэгжилт – 89.7%;
- Засгийн газрын 8 албан даалгаврын 8 заалтын хэрэгжилт – 95.7%
- Ерөнхий сайдын 2 захирамж 2 заалтын хэрэгжилт - 100.0%
- ҮАБЗ-ийн 2 зөвлөмж 2 заалтын хэрэгжилт - 85%

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг яамны удирдлагын зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/346 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулан баталгаажуулав.

1.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 16 зорилтын 75 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хяналтад авсан 75 арга хэмжээний 55 арга хэмжээг тус яам толгойлон, 20 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба хэрэгжилт **69.5** хувийн биелэлттэй гэж дүгнэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,
- Эдийн засгийн бодлогын хүрээний 11 зорилтын 70 арга хэмжээний биелэлт 68.7 хувь,
- Засаглалын бодлогын хүрээний 3 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,
- Ногоон хөгжлийн бодлогын 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 100.0 хувьтай дүгнэлээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

/2023 оны жилийн эцсийн байдлаар/

Зорилт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо						Хэрэгжилт /хувь/
			100	90	70	50	30	0	
Нэг. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	1	1	1	0	0	0	0	0	100
Хоёр. Эдийн засгийн бодлого	11	70	13	21	14	6	8	8	67.3
Дөрөв. Засаглалын бодлого	2	2	2	-	-	-	-	-	100
Тав. Ногоон хөгжлийн бодлого	2	2	2	-	-	-	-	-	100
Дүн	16	75	18	21	14	6	8	8	69.5

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 2023 оны жилийн эцсийн байдлаар **69.5** хувьтай дүгнэснээс 18 арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрч 100 хувийн гүйцэтгэлтэй, 21 арга хэмжээ гол үр дүн гарч эхэлж байгаа буюу 90 хувь, 14 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувь, 6 арга хэмжээ ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувь, 8 арга хэмжээ боловсруулалтын шатанд буюу 30 хувь, үр дүнгүй 8 арга хэмжээ байна.

1.3. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 2 зорилгын 21 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үнэлгээг 2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /unelgee.gov.mn/ цахим системд байршуулсан 2 зорилтын 21 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Хяналтад авагдсан 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан ба биелэлт 69.5 %-тай дүгнэгдэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилгоор нь авч үзвэл:

- Зорилго 2.4. “Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.” зорилгын хэрэгжилт 70.5 хувь,
- Зорилго 4.1. “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ” зорилгын хэрэгжилт 60.0 хувь

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Зорилго	Арга хэмжээний тоо	Үнэлгээ (хувь)						Хэрэгжилт /хувь/
		100	90	70	50	30	0	
Зорилго 2.4. Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.	19	-	9	5	3	1	1	70.5
Зорилго 4.1. Ногоон хөгжлийн сэргэл-тийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	2	-	1	-	-	1	-	60.0
Нийт дүн	21	-	10	5	3	2	1	69.5

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 69.5 хувьтай дүгнэгдэж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулж баталгаажуулав.

1.4. САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, Яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт батлах тухай Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолыг тус тус удирдлага болгон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд геологийн зураглал, голлох эрдэс түүхий эдийн олборлолт, экспорт, газрын тосны бүтээгдэхүүний импорт, металл, шатах ашигт малтмалын үйлдвэрлэлийн 10 ангиллын 18 үзүүлэлтээр дүгнэхэд тайлант хугацаанд 7 үзүүлэлт зорилтот түвшинд хүрсэн буюу давж биелсэн бол үлдсэн 11 үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй, үзүүлэлт буурсан гүйцэтгэлтэй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 93.0 хувьтай, 4.7 оноогоор дүгнэгдлээ.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ	
			2020	2023	2023	Хувь	Оноо
1	Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн 1:50 000-ын масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдалт (хувь)	хувь	41.1	46.0	44.0	95.7%	4.9
2	Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн 1:200000-ын масштабын иж бүрэн зураг нэгтгэх төслийн хэрэгжилт (бүх нутгийг хамарсан байх)	хувь	30.0	100.0	100.0	100.0%	5.0
3	Голлох эрдэс түүхий эдийн олборлолтын хэмжээ						
	Газрын тос (мян.бар)	бар	4,199.1	5 982.7	4,888.9	81.7%	4.1
	Нүүрс (сая тн)	сая тн	38.0	71.0	83.2	117.2%	5.0
	Зэсийн баяжмал (мян.тн)	мян.тн	1,270.0	2188.0	1,395.3	63.8%	3.2
	Төмрийн хүдэр (сая тн)	сая тн	8.2	9.5	5.3	56.1%	2.8
	Алт (тн)	тн	19.0	23.0	14.9	64.6%	3.2
4	Голлох эрдэс түүхий эдийн экспортын хэмжээ						
	Газрын тос (мян.бар)	бар	4,198.8	5 922.9	4,730.4	79.9%	4.0
	Нүүрс (сая тн)	сая тн	25.0	45.0	69.6	154.7%	5.0
	Зэсийн баяжмал (мян.тн)	мян.тн	1,270.0	2188.0	1,524.8	69.7%	3.5
	Төмрийн хүдэр (сая тн)	сая тн	8.2	9.5	5.7	60.1%	3.0
	Алт (тн) Монгол банканд тушаасан	тн	19.0	23.0	11.7	51.0%	2.6
5	Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ						
	Үүнээс: ОХУ-аас	сая тн	1.9	2.2	2.2	98.4%	4.9
	Бусад улсаас	сая тн	0.1	0.1	0.1	100.0%	5.0
6	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл (тн)						
	Катодын зэс 99%	тн	9,300.0	9,300.0	9,661.3	101.4%	5.0
	Цахилгааны утас	тн	72.0	80.0	70.2	87.8%	4.4
	Метал бэлдэц	тн	15,507.0	35,350.0	37,680.5	106.6%	5.0
	Метал цувимал	тн	16,675.0	33,000.0	36,117.9	109.4%	5.0
УУХҮЯ-ны ЭЗНХҮ-ийн биелэлтийн ерөнхий үнэлгээ						93.0%	4.7

2. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.1 БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 8 зорилгын 24 зорилтын 168 арга хэмжээний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **93.5** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

- ❖ Зорилго 1. /Нутаг дэвсгэрийн 2-20%-ийг геологийн судалгааны ажилд хамруулан ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөж, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2022 онд 15.6 их наяд төгрөг байсныг 2023 онд 15.7 их наяд төгрөг болгон нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийг 2023 онд 7.7 хувьд хүргэж, газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2023 онд 866.6 мян.тн-д хүргэнэ./-д хамаарах 63 арга хэмжээний хэрэгжилт – 89.5%;
- ❖ ЗОРИЛГО 2. /Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшнийг 2020 онд 84.7 хувь байгааг 2023 онд 85 хувьд хүргэнэ./-д хамаарах 13 арга хэмжээний хэрэгжилт – 86.4%;
- ❖ ЗОРИЛГО 3. /Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэж, яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшнийг 2020 онд 84.7 хувь байгааг 2023 онд 85 хувьд хүргэнэ./-д хамаарах 25 арга хэмжээний хэрэгжилт – 98.0%;
- ❖ ЗОРИЛГО 4. /Салбарын хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2022 оны түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээ авна. /-д хамаарах 20 арга хэмжээний хэрэгжилт – 94.5%;
- ❖ ЗОРИЛГО 5. /Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа 2019 онд 47.5 хоног байгааг 2023 онд 25 хоногт хүргэнэ./-д хамаарах 19 арга хэмжээний хэрэгжилт - 100.0%;
- ❖ ЗОРИЛГО 6. /Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгч, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн ЗГХЭГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээгээр 2021 оны

зорилтот түвшин, хүрсэн түвшин хоорондын зөрүү 1.5 байсныг 2022 онд 1.3 болгон бууруулна./-д хамаарах 2 арга хэмжээний хэрэгжилт - 100.0%;

- ❖ ЗОРИЛГО 7. /Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангаж e-mongolia төрийн нэгдсэн үйлчилгээнд нэгдэнэ./-д хамаарах 12 арга хэмжээний хэрэгжилт – 91.7%;
- ❖ ЗОРИЛГО 8. /Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу эрсдэлд суурилсан хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулна./-д хамаарах 14 арга хэмжээний хэрэгжилт – 92.1%-ийн тус тус биелэлттэй байна.

БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

Зорилго, зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц /хувиар/							Хэрэгжилт /хувь/
		100	90	70	50	30	0	/-/	
ЗОРИЛГО 1. Нутаг дэвсгэрийн 2-20%-ийг геологийн судалгааны ажилд хамруулан ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөж, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2022 онд 15.6 их наяд төгрөг байсныг 2023 онд 15.7 их наяд төгрөг болгон нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийг 2023 онд 7.7 хувьд хүргэж, газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2023 онд 866.6 мян.тн-д хүргэнэ.									
1. ЗГҮАХ-3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ. ШСБ-ын 3.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн, эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулна.	9	2	2	4	-	1	-	-	76.7
Зорилт 2 - ЗГҮАХ-3.2.2.Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	2	2	-	-	-	-	-	-	100.0
Зорилт 3. ШСБ-3.1.2, ЗГҮАХ-3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	8	6	-	1	-	-	1	-	83.8

Зорилт 4 - ЗГҮАХ-3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.	2	2	-	-	-	-	-	-	100.0
5. ШСБ-3.1.1, ЗГҮАХ-3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.	5	4	-	1	-	-	-	-	94.0
6. ШСБ-3.1.1, ЗГҮАХ-3.2.16. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.	5	5	-	-	-	-	-	-	100.0
7. ЗГҮАХ-3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшнийг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.	20	13	-	2	2	-	-	3	90.6
8. ШСБ-3.3, ЗГҮАХ-3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.	12	10	-	-	2	-	-	-	95.0
Дүн	63	45	2	8	4	0	1	3	91.2
ЗОРИЛГО 2. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшнийг 2020 онд 84.7 хувь байгааг 2023 онд 85 хувьд хүргэнэ.									
Зорилт 1 Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож сайжруулна.	13	8	-	-	3	-	-	2	86.4
Дүн	13	8	-	-	3	-	-	2	86.4
ЗОРИЛГО 3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэж, яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшнийг 2020 онд 84.7 хувь байгааг 2023 онд 85 хувьд хүргэнэ.									

УУХУЯ-ны 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

Зорилт 1 Салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	21	20	-	-	1	-	-	-	97.6
Зорилт 2 Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.	4	4	-	-	-	-	-	-	100.0
Дүн	25	24	-	-	1	-	-	-	98.0
ЗОРИЛГО 4. Салбарын хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2022 оны түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээ авна.									
Зорилт1 Салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, статистикийн мэдээлэл, судалгаа шинжилгээний ажлын чанар, хүртээмжийг сайжруулна.	12	11	-	1	-	-	-	-	97.5
Зорилт 2 Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.	8	6	-	1	1	-	-	-	90.0
Дүн	20	17	-	2	1	-	-	-	94.5
ЗОРИЛГО 5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа 2019 онд 47.5 хоног байгааг 2023 онд 25 хоногт хүргэнэ.									
Зорилт 1 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	6	6	-	-	-	-	-	-	100.0
Зорилт 2 Салбарын хууль, эрх зүйн орчны давхардал хийдлийг арилгах, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно.	4	4	-	-	-	-	-	-	100.0
Зорилт 3 Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын багцын төсвийн гүйцэтгэл 2022 онд 95 хувь байсныг 2023 онд 2.0 хувиар нэмэгдүүлж, төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлнэ.	6	6	-	-	-	-	-	-	100.0
Зорилт 4 Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	3	3	-	-	-	-	-	-	100.0
Дүн	19	19	-	-	-	-	-	-	100.0

<p>ЗОРИЛГО 6. Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгч, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн ЗГХЭГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээгээр 2021 оны зорилтот түвшин, хүрсэн түвшин хоорондын зөрүү 1.5 байсныг 2022 онд 1.3 болгон бууруулна.</p>										
Зорилт 1	Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийнэ.	1	1	-	-	-	-	-	-	100.0
Зорилт 2	Санхүүгийн болон үйл ажиллагааны дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллана.	1	1	-	-	-	-	-	-	100.0
Дүн		2	2	-	-	-	-	-	-	100.0
<p>ЗОРИЛГО 7. Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангаж e-mongolia төрийн нэгдсэн үйлчилгээнд нэгдэнэ.</p>										
Зорилт 1	Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангаж e-mongolia төрийн нэгдсэн үйлчилгээнд нэгдэнэ.	12	10	-	-	2	-	-	-	91.7
Дүн		12	10	-	-	2	-	-	-	91.7
<p>ЗОРИЛГО 8. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу эрсдэлд суурилсан хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулна.</p>										
Зорилт 1	Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, тайлагнах, хэрэгжилтийг хангуулах, дотоод хяналтыг зохион байгуулна.	1	1	-	-	-	-	-	-	100.0
Зорилт 2	Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хяналт тавих, үйл ажиллагаанаас учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулна.	9	8	-	1	-	-	-	-	96.7
Зорилт 3	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг эрсдэлийн судалгаанд үндэслэн хэрэгжүүлэх, хяналт шалгалтын мэдээллийн баазыг өргөжүүлэх замаар эрсдэлийн	2	-	-	1	1	-	-	-	60.0

удирдлагын төлөвшүүлнэ.	тогтолцоог								
Зорилт 4 Салбарын хяналтын дотоод үйл ажиллагааны удирдлага, зохицуулалтыг сайжруулж, хяналтын үндсэн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг оновчтой болгоно.	2	2	-	-	-	-	-	-	100.0
Дүн	14	11	-	2	1	-	-	-	92.1
Нийт дүн	168	136	2	12	12	-	1	5	93.5

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 8 зорилгын 24 зорилтын 168 арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтийг **93.5** хувийн биелэлттэй гэж дүгнэв.

Нийт 168 арга хэмжээний биелэлтийг дүгнэсэн 136 арга хэмжээ 100 хувийн хэрэгжилттэй, 2 арга хэмжээ нь 90 хувийн хэрэгжилттэй, 12 арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй, 12 арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй, хэрэгжээгүй 1 арга хэмжээ байна.

2.2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтаар төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан.

Тус журмын 6 дугаар хэсэгт заасны дагуу хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх 3 үйл ажиллагаа, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 4 үйл ажиллагаа, нийт 7 шалгуур үзүүлэлтийн биелэлтэд үнэлгээ өгөв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр яамны Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг **100%**-тай дүгнэв.

Яамны 2023 оны төсөвт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, шаардлагатай техник хэрэгслийг шинэчлэх, зэрэг дэв, цалингийн шатлал ахиулах, хоол унааны нэмэгдлийн төсвийг батлуулж хэрэгжүүлсэн байна.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хэрэгжилт /хувь/
		1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх	
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургууль, Мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан 7 сэдвээр богино хугацааны сургалтад давхардсан тоогоор нийтдээ 35 албан хаагчийг хамруулан сертификат авчээ. Үүнд: 1.Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт-5 2.Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт-6 3.Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт-6 4.Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалт-7 5.Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт-8 6.Төрийн албан дахь харилцаа, маркетинг богино хугацааны зайн сургалт-1 7.Төсвийн хөрөнгө оруулалт, үр ашгийн болон эрсдэлийн шинжилгээ сургалт-2	100
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2023 онд нийт 2 албан хаагч магистрын зэрэг хамгаалахаар гадаад улсад суралцагч талын зардлаар суралцаж байна. Үүнд: Австрали улсад магистрт 1 албан хаагч, Япон улсын Засгийн газраас хэрэгжүүлдэг Монгол Улсын төрийн албаны хүний нөөцийг дэмжих JDS тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэж тус улсын Кюүшүгийн их сургуулийн хуулийн магистрын хөтөлбөрт 1 албан хаагч тус тус суралцаж байна.	100
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	1. Гамшгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-т заасан гамшгийн өмнөх үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тулгуурлахаар заасан бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нийт албан хаагчдад Гамшгийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасанчлан сургаж дадлагажуулахаар гамшгаас хамгаалах сургалтыг, Авлигаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны эсрэг гэмт хэргийн өнөөгийн байдал сэдвээр Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан. Авлигын эсрэг сургалтад яамны албан хаагчдыг хамруулан холбогдох мэдээллийг өгч нийт 57 албан тушаалтан сургалтад хамрагдсан. Мэдээлэл хариуцагчийн зардлаар 2023 онд Геологийн бодлогын газрын ахлах шинжээч Х.Баярхангай МУИС-Байгалийн Шинжлэх Ухааны Сургуульд докторын зэргээр суралцсан. Сургалтын төлбөр 2.9 сая төгрөг. 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2023 онд Нийслэлийн засаг даргын тамгын газарт 2, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 1, Ашигт малтмал газрын тосны газарт 2 албан хаагч шилжин ажилласан бөгөөд тус яаманд Ашигт малтмал, газрын тосны газраас 3 албан хаагч тус тус шилжүүлэн авч ажиллаж байна.	100
	2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах		

4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8 дугаар хэсгийн 8.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн нийт албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг 4 удаа, нийт 368.3 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.	100
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	Албан хаагчдын ажлын байранд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан. Үүнд: 1. Ажлын байрны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд Засгийн газрын байрнуудын нийтлэг үйлчилгээний газраар байрны сантехникийг шалгуулах, цахилгааны холболт, өрөөний цоож, хаалга засварлуулах, байрны цэвэрлэгээ үйлчилгээнд анхаарч ажилласан. 2. УУХҮЯ-ны барилгын дээврийн засварын ажил, дотор заслын ажлуудыг гүйцэтгүүлсэн. Дээврийн ажилд 177.6 сая төгрөг, дотор заслын ажилд үүдний хэсгийн засал, шатны хэсэг, коридор, албан хаагчдын өрөө тасалгаа болон жендерийн өрөөг засварлаж тохижуулах ажилд 199.0 сая төгрөг зарцуулсан. 3. Мэдээллийн технологийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж 50.8 сая төгрөг, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж шинэчлэхэд зориулж 19.8 сая төгрөгийг зарцуулсан.	100
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад зориулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны төсөвт 26.7 сая төгрөгийн төсвийг батлуулсан. Яамны нийт 89 албан хаагчдыг Улаанбаатар Сөүл сэниорс товер ХХК-ны Улаанбаатар-Сонгодо эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад зориулан 26.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан.	100
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2023 онд нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлаас 66.2 сая төгрөгийг албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад зарцуулсан байна. Улаанбаатар хотын захиргаанд яамны 86 албан хаагчдад зуслангийн газар олгуулах хүсэлтийг тавьсан ба 2023 оны эхний улиралд шийдвэрлэн газар олголт хийгдсэн.	100
ДҮН			100

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

д/д	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	-	37	
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	-	12	
			Мэргэшүүлэх сургалт	-	21	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-	
			Бусад	-	4	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	128 давхардсан тоогоор	

		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	38	
			Эрэгтэй албан хаагч	-	90	
			Удирдах албан тушаалтан	-	16	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	112	
		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	104.5 хувь	
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	-	Төсвийн хэмнэлтийн хуулийн дагуу гадаад сургалт байхгүй болно.
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	-	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	-	
			Эрэгтэй албан хаагч	-	-	
			Удирдах албан тушаалтан	-	-	
2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	2.2 хувь			
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	10.0	2.9	
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	3.3 хувь	
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь		40.6 хувь	
		4.2	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл /нэг өдөрт/ (мян.төг)	-	20.0	

5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	100 хувь
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	1 удаа
		6.2	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	100 хувь
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	66.2

3. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

3.1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтаар чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 10, хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 6, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 15, үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 2, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 13 нийт 46 үзүүлэлтээр биелэлтийг гаргуулж үнэлгээг өгөв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр нийт шалгуур үзүүлэлтийг **97.9** хувийн биелэлттэй дүгнэв.

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

№	Шалгуур үзүүлэлт	Заалт	Биелэлт, %/				Хугацаа болоогүй	Хэрэгжилт /хувь/
			100	70	30	0		
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	7	3	-	-	-	97.0
2	Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	4	2	-	-	-	96.7
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	12	3	-	-	-	98.0
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	2	-	-	-	-	100.0
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	13	8	1	-	-	4	98.9
Хэрэгжилтийн дундаж		46	33	9	-	-	4	97.9

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд хийсэн үнэлгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

3.2. ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.8-д шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 03 дугаар сарын 01-ний дотор хүргүүлдэг.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/78 дугаар тушаалаар баталсан журмын дагуу УУХҮЯ-ны шилэн дансны мэдээлэл, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Мэдээллийг хуулийн хугацаанд мэдээ, мэдээллийг байршуулсан эсэх, мэдээллийг үнэн зөв, бүрэн, ил тод мэдээлсэн эсэхэд тухай бүр, сар, улирал тутам хяналт тавьж, системд тайлагнаж ажилласнаар хуулийн хэрэгжилт сайжирсан.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр А/31 дүгээр тушаалаар баталсан “Дотоод аудитын төлөвлөгөө”-ний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага дахь “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд дотоод хийсэн.

Сангийн яамнаас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг **96.0** хувиар дүгнэгдсэн байна.

3.3. ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.7-д заасны дагуу уг үзүүлэлтийг Авлигатай тэмцэх газар /АТГ/-аас гаргаж ЗГХЭГ-т хүргүүлдэг.

Авлигын эсрэг хуулийн 18.1.7. “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу УУХҮЯ шударга байдлын үнэлгээгээр 2021 онд **72.4** оноо, 2022 онд **71.2** оноо тус тус авсан байна.

3.4. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд, Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсонтой холбоотойгоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.6-д “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар жил бүр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг бүх аймаг, нийслэлийг хамруулан хийх ажлыг зохион байгуулна, шаардагдах зардлыг төсөвт тусган батлуулсан байна. Захиргааны байгууллага салбарын болон орон нутгийн хэмжээнд бодлогын баримт бичгийн үр дүн, үр нөлөөг судлах, захиргааны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг хийж болно. Хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан ерөнхий удирдамжийг баримтлан хөндлөнгийн байгууллагыг судалгааны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын дундаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг харгалзан сонгон шалгаруулна” гэж заасны дагуу ЗГХЭГ-аас хэрэглэгчийн үнэлгээг нэгдсэн байдлаар хийлгэхээр шийдвэрлэсэн.

4. БУСАД ТАЙЛАН

4.1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, аймгуудын Засаг дарга нартай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу гүйцэтгэв.

Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд өгсөн үнэлгээний үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв. Ерөнхий үнэлгээ **73.8** хувьтай байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

№	Аймгийн нэр	Засаг даргын нэр	Гэрээний дугаар	Заалтын тоо	Дүгнэсэн арга хэмжээний биелэлтийн хувь							Биелэлт хувь
					100	90	70	50	30	0	-	
1	Архангай	Б.Цэрэннадмид	1	32	2	8	4	4	3	1	10	67.7
2	Баян-Өлгий	А.Камелият	2	36	9	12	7	2	4	-	2	79.1
3	Баянхонгор	Д.Мөнхсайхан	3	31	8	11	4	2	2	-	4	82.6
4	Булган	Б.Ариун-Эрдэнэ	4	26	3	6	3	1	4	2	7	64.2
5	Говь-Алтай	О.Амгаланбаатар	5	31	3	11	9	1	2	2	3	72.5
6	Говьсүмбэр	Г.Батсуурь	6	33	2	12	9	1	2	-	7	77.7
7	Дархан-Уул	Б.Азжаргал	7	29	14	10	2	1	1	-	1	90.0
8	Дорноговь	О.Батжаргал	8	39	8	18	5	4	2	-	2	81.9
9	Дорнод	М.Бадамсүрэн	9	39	6	11	6	9	2	3	2	68.1
10	Дундговь	Ц.Мөнхбат	10	23	9	9	3	-	-	1	1	87.2
11	Завхан	Г.Өнөрбаяр	11	31	2	6	6	6	4	2	5	60.8
12	Орхон	С.Батжаргал	12	32	7	12	8	3	2	-	-	79.4
13	Өвөрхангай	И.Доржсүрэн	13	36	5	8	7	6	5	3	2	63.5
14	Өмнөговь	Р.Сэддорж	14	41	16	15	6	1	1	-	2	88.5
15	Сүхбаатар	М.Идэрбат	15	33	6	8	9	5	1	-	4	76.9
16	Сэлэнгэ	Н.Лхагвадорж	16	34	7	7	7	6	5	-	2	70.9
17	Төв	Д.Мөнхбаатар	17	32	6	10	6	5	3	1	1	72.9
18	Увс	Ч.Чимэд	18	33	3	8	8	7	1	-	6	72.6
19	Ховд	Э.Болормаа	19	33	4	11	5	4	2	5	2	64.5
20	Хөвсгөл	П.Лхагважав	20	23	1	3	9	4	-	2	4	63.2
21	Хэнтий	Ц.Чогсомжав	21	33	6	12	7	3	2	2	1	74.4
22	Улаанбаатар	Х.Нямбаатар	22	25	5	3	3	4	2	2	6	65.3
Үнэлгээний дүн				705	132	211	133	79	50	26	74	73.8

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд аймаг, нийслэлийн засаг дарга нартай 2023 онд нийт 705 заалт бүхий хамтран ажиллах гэрээ байгуулсан. Үүнээс үр дүнтэй хэрэгжсэн 132, тодорхой үр дүнд хүрсэн 344, эрчимжүүлэх шаардлагатай 129, үр дүнгүй 26 заалт, хэрэгжээгүй буюу үнэлгээ хийгдээгүй 76 заалт байгаа бөгөөд нийт гэрээний үүргийн биелэлт 73.8 хувийн хэрэгжилттэй дүгнэгдлээ. Гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ хэрэгжээгүй буюу үнэлгээ хийгдээгүй заалтуудыг хасаж тооцсон, мөн

аймгуудын гэрээний заалтын тоо харилцан адилгүй байгаа нь хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн бодит бус гарахад нөлөөлж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах нийтлэг зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

1. Гэрээний заалтыг аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулж, тухайн орон нутгийн онцлогийг харгалзан, үр дүнд суурилсан байдлаар боловсруулаагүйгээс нийт 705 заалт бүхий гэрээнээс 74 заалт хэрэгжээгүй буюу үнэлэх боломжгүй байна. Тухайлбал, Архангай аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 10, Булган аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 7, Говьсүмбэр аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 7 заалт тус тус хэрэгжээгүй буюу үнэлгээ хийгдээгүй байна.

2. Гэрээний хэрэгжилтийг тогтсон загварын дагуу тайлагнадаггүй, хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг тайлангийн хамт ирүүлдэггүй;

3. Өмнөх онуудын гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, санал зөвлөмжийн дагуу дараа жилийн хамтран ажиллах гэрээний заалтыг боловсруулаагүйгээс ихэнх аймгуудад дараах заалтууд жил дараалан хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- Орон нутагт боловсруулах үйлдвэр байгуулах болон түүнтэй холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хууль, журмын хүрээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;
- Аймаг, орон нутагт салбарыг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж төсөл, арга хэмжээг бодлогын хувьд дэмжих, аливаа хөтөлбөр, томоохон төсөлд урьдчилан санал авч байх.

4. “Хамтран ажиллах”, “дэмжлэг үзүүлэх” гэсэн заалтын хүрээнд хийсэн ажлыг тодорхой бус тайлагнаж байна. Мөн “Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 04, 05, 06 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах”, “ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/114 дугаар тушаалаар батлагдсан Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан (1.4-1.10; 2.1-2.9; 3.1-3.2; 4.1-4.8) холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, биелэлтийг 2023 оны 11 дүгээр сард багтаан ирүүлэх” заалтын хэрэгжилтийг албан даалгавар, зүйл тус бүрээр тайлагнах;

5. Тайлан, мэдээ болон санал хүргүүлэх тодорхой хугацаа заасан дараах заалтуудын хэрэгжилтийг албан бичгийн огноо, дугаарыг бичиж, үнэн зөв тайлагнаагүйгээс үнэлгээ буурч байна. Үүнд:

- Түгээмэл тархацтай ашигт малтмал, барилгын материалын ашиглалт, олборлолтын мэдээ, нөөцийн хөдөлгөөний мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газрын чиглэл хариуцсан нэгжид улирал бүр ирүүлэх;
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа боловсруулах үйлдвэрүүдийн ерөнхий мэдээллийг хагас жил тутам буюу тухайн жилийн 07 дугаар болон 12 дугаар сарын эхний хагаст багтаан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлэх;
- Орон нутгийн онцлог, давуу талд тулгуурласан эдийн засаг нийгэмд бодит хувь нэмэр оруулах, боловсруулах үйлдвэр байгуулах боломжийн талаар судалгаанд суурилсан санал боловсруулж, II улиралд багтаан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлэх зэрэг заалтууд болно.

6. Тухайн орон нутагт хэрэгжих боломжгүй заалтыг жил бүр гэрээнд тусгаж байгаа нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэлтэй байна.

7. Гэрээний заалтыг хүрч болохуйц, бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан байдлаар тодорхойлж, хийж гүйцэтгэсэн ажлыг бүрэн гүйцэд тайлагнаж, хүрсэн түвшнийг үнэн зөв, бодитой үнэлэх шаардлагатай байна.

Аймгийн Засаг дарга нартай байгуулсан, хамтран ажиллах гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

4.2. ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГГИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 5 гадаадын зээл, тусламжийн төсөл 2023 онд хэрэгжсэн бөгөөд эдгээр төслүүд бүгд буцалтгүй тусламжаар, санамж бичиг болон гэрээний хүрээнд хэрэгжиж байна.

Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн төслийн хэрэгжилтийн үнэлгээгээр 2023 оны жилийн эцсийн байдлаар "тодорхой үр дүнд хүрсэн"-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай /70-100 хувь/ 3 төсөл, "эрчимжүүлэх шаардлагатай"-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай /30-70%/ 2 төсөл байна.

ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

д/д	Төслийн нэр	Зорилтын тоо	Үнэлгээ (хувь)						Хэрэгжилт (хувь)
			100	90	70	50	30	0	
1	"МУ-ын агаарын чанарыг сайжруулах эрчим хүчний нөөцийн чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх" төсөл	3	-	1	1	1		-	70.0%
2	"Монгол Улсын Эрдэс баялгийн салбар дахь институцийн болон боловсон хүчний чадавхыг хөгжүүлэх II" БГР төсөл	3	-		2	1		-	63.3%
3	Австрали Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр II	5	-		2	1	2	-	50%
4	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг бэхжүүлэх төсөл	3	-	1	2			-	76.7%
5	Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT)	3	-	2	1			-	83.3%
	Нийт дүн	17	-	4	8	3	2	-	66.4%

Сангийн яамны албан тоотоор ирүүлсэн хавсралт хүснэгтийн дагуу гадаад зээл, тусламжийн төслүүдийн үнэлгээ, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT) бүрэн тайлагнаагүй болно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд ХБНГУ-ын Эдийн засаг, Хамтын ажиллагаа, Хөгжлийн Холбооны Яам, Канад улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар, Дэлхийн банк, Австрали улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 5 төсөл хэрэгжиж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжийн 5 төслийн хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 66.4 хувьтай үнэлэгдэв.

4.3. УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх 9 төсөл байгаагаас уул уурхайн 6, хүнд үйлдвэрийн 2, газрын тосны 1 төсөл байна. Хөтөлбөрт тусгагдсан 9 төслийн 2023 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл 67.7 хувь, санхүүжилтийн гүйцэтгэл 53.3 хувийн биелэлттэй дүгнэгдэв.

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ (2023 онд төлөвлөсөн ажил болон санхүүжилтийн гүйцэтгэлээр)

№	Төслийн нэр	Ажлын гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ	Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ
1	Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах	98.0%	90	34.8%	30
2	Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл.	9%	30	1.2%	0
3	Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэл, ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулах төсөл	84.0%	90	60.6%	70
4	Цагаансуваргын зэс, молибдений ордыг ашиглалтад оруулах төсөл	69.0%	70	36.1%	50
5	Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл	4.7%	30	1.6%	0
6	Тавантолгойн нүүрсний бүлэг ордод технологийн шинэчлэл хийж, олборлолтыг төслийн хүчин чадалд хүргэх, нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах төсөл	64%	70	134.1%	100
7	Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглах төсөл	100%	100	100%	100
8	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	7%	30	19.3%	30
9	Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах төсөл	100%	100	100%	100
Үнэлгээний дүн			67.7		53.3

“Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн тодорхой ажил хийгдсэн боловч зорилтот түвшиндээ хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай, боловсруулалтын шатанд байгаа дараах төслүүд байна. Үүнд:

Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл:

Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр хэлэлцүүлж, АМГТГ-ын даргын “Техник эдийн засгийн үндэслэл бүртгэх тухай” 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Т/39 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авсан.

ТЭЗҮ-д тусгаснаар: зэсийн үнийг 8500\$/тн-оор тооцож, нийт хөрөнгө оруулалтыг 109.8 сая.\$ буюу 362.4 тэрбум төгрөг, үүний анхны хөрөнгө оруулалт 197.6 тэрбум төгрөг, ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт 164.8 тэрбум төгрөг байхаар тооцсон.

“SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах” гэрээ байгуулсан “Майнинг Шорт Лонг Терм” ХХК-д гэрээний дагуу 2021.11.24-ний өдөр 30% буюу 732.38 сая төгрөг, ажлын хэсгийн хурлын шийдвэр болон тайлангийн явцын гүйцэтгэлээр 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр 33.8% буюу 852.4 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажилд нийт 1,584.78 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд: байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх ажилд 142.5 сая төгрөг, техник технологийн түвшний үнэлгээ хийх ажилд 100 сая төгрөг, ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын үлдэгдэл төлбөрийг тус тус төлөвлөсөн.

Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл:

Ажлын явцын хувьд ТЭЗҮ батлагдсан, нарийвчилсан зураг төсөл боловсруулах техникийн даалгавар боловсруулсан.

Үйлдвэрлэл, технологийн паркийн газрын хил заагийн эргэлтийн цэгийг тэмдэгжүүлж, солбицол тодорхойлсон, 1:500 масштабтай байр зүйн дэвсгэр зургийг боловсруулсан, хашаа барих ажлын явц 90%.

Дэд бүтцийн ажлын хувьд авто зам барьж байгуулах ажлын явц 36%, төмөр зам барьж байгуулах ажлын явц 68%. Ул хөрсний төлөвлөгдөөгүй нэмэлт ажил, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан гэрээний хугацааг сунгах ажил явагдаж байна.

Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтын ажил Ковид цар тахлаас шалтгаалан 2022 онд ажил бүрэн зогссон, 2023 онд туршилтын үйлдвэрийн бүх тоног төхөөрөмж, барилга угсралтын ажил 100% дуусаж туршилтын ажил үргэлжилж байна.

Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааг үйлдвэрийн судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна.

Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх төсөл:

Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д даалгасан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 03-р сарын 31-ний 01/801 тоот албан бичгээр ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын нарийвчилсан төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх саналаа яаралтай танилцуулахыг үүрэг болгосон.

Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 2023 оны байдлаар 7%-тай хэвээр байна.

4.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны худалдан авах ажиллагаа 2023 оны жилийн эцсийн байдлаар 3,762,424.20 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төрлийн худалдан авалтад 3,738,161.35 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 24,262.8 мянган төгрөгийг хэмнэж зарцуулсан байна. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг гаргахад **94.6** оноогоор үнэлэгдэв.

Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын талаар

Нээлттэй тендер шалгаруулалт:

- Урсгал засвар- 2 багцтай
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил-1 зөвлөх үйлчилгээний хосолмол үнэлгээний аргаар 1 багцыг
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил-2 зөвлөх үйлчилгээний чанарын үнэлгээний аргаар 2 багцыг
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2022 оны нэгтгэл тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээний хосолмол үнэлгээний аргаар 1 багцыг

Харьцуулалтын арга:

Мэдээллийн технологийн үйлчилгээг сонгон шалгуулж гэрээ байгуулан үйлчилгээг авсан.

Шууд худалдан авалт:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгох босго үнийг үндэслэн шууд худалдан авалт 13 төрлийн худалдан авалт хийсэн. Үүнээс цахим худалдан авалт /ерөнхий гэрээ/-аар 6 бараа ажил үйлчилгээг авсан.

Худалдан авах ажиллагааны явцад тендерийн хүчинтэй хугацаанд тендерт оролцогчоос гомдол гараагүй.

Урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авах 14, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 3, төсвийн хэмнэлтээс 1 төсөл, арга хэмжээг тус тус сонгон шалгаруулсан байна.

Худалдан авах ажиллагааны цахим систем ашигласан талаар

- Худалдан авалтыг 100 хувь цахим системээр зохион байгуулж ажилласан бөгөөд цахим худалдан авалт /ерөнхий гэрээ/-аар 6 нэр төрлийн 73.4 сая төгрөгийн өртөгт бүхий бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан. Үүнд: Тендерийн зар нийтлүүлэх, техник тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн үйлчилгээ багтаж байна.

Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар

- Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт **93.0** хувиар, Үндэсний геологийн албаны 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт **94.3** хувиар тус тус үнэлэгдлээ.

Б. ДҮГНЭЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2023 онд Бодлогын баримт бичигт тусгагдсан томоохон бүтээн байгуулалтын ажлууд болох Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах, Оюу Толгойн төслийн далд уурхайг ашиглалтад оруулах, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийх, Таван толгойн нүүрсний бүлэг ордод технологийн шинэчлэл хийж, олборлолтыг төслийн хүчин чадалд хүргэх ажлуудыг амжилттай хэрэгжүүлж ажиллаа. Үүний үр дүнд эрдэс баялгийн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 27 хувь, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 71 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 78 хувь, экспортын орлогын 92 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 77 хувь, улсын төсвийн орлогын 34 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Түүнчлэн Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжсанаас ашигт малтмалыг зах зээлийн бодит үнээр борлуулах, арилжааны болон гэрээ, хэлцэл ил тод болох, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид үнэн бодит мэдээллээр хангагдах, уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, албан татвар, төлбөр хураамжийг бодитой ногдуулах зэрэг эдийн засагт эерэг нөлөөллүүд гарч улмаар уул уурхайгаас орсон орлогоос иргэдэд ноогдол ашиг хүртээгээд байна.

Улсын төсвийн хөрөнгөөр Монгол орны нутаг дэвсгэрийн 44 хувь буюу 688 мянган км.кв талбайг 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд хамруулсны үр дүнд: 2022 онд төмөр 2,187.2 мян.тн, ванади 4.6 мян.тн, зэс 26,339.7 мян.тн, молибден 108.6 мян.тн, алт 20.4 тн, цагаан тугалга 34.1 мян.тн, мишьяк 241.1 мян.тн, хром 526.6 мян.тн, никель 189.5 мян.тн, гипс 603.7 мян.тн баялгийг илрүүлэн үнэлсэн, 2023 онд мөнгө 3,085 кг, зэс 216.5 мян.тн, цайр 23.6 мян.тн, сурьма 19.5 мян.тн, вольфрам 12.5 мян.тн, молибден 13.8 мян.тн, никель 8.7 мян.тн, хар тугалга 17.0 мян.тн, хүнцэл 647.7 мян.тн, төмөр 5,825.5 мян.тн, мангани 53.4 мян.тн, өнгөлгөөний чулуу 30,000 м3, шавар 4,628.0 тэрбум тн баялгийг илрүүлэн үнэлгээ өгсөн.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөх, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цэгцэлж, олон нийтэд нээлттэй болгох зорилтын хүрээнд 2023 онд 2,3 сая га талбайг хамарсан 450 талбайд сонгон шалгаруулалтыг зарласны үр дүнд 1,06 сая га талбай бүхий 209 тусгай зөвшөөрөл олгож, улсын төсөвт 47,8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэв.

Монгол Улсын хэмжээнд нийт 14 аймгийн нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын 35 талбай ялгасан бөгөөд газрын тосны хайгуулын чиглэлээр 9 талбайд, нүүрсний давхаргын метан хийн чиглэлээр 6 талбайд тус тус Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, ашиглалтын 4 талбайгаас газрын тос олборлож байна. Шинээр 5 талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах хэлцэл хийгдэж байна. Түүнчлэн нийт 9 талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахаар олон улсын сонгон шалгаруулалт зарласан.

Газрын тосны экспортоос улсын төсөвт 2023 оны 12 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар Газрын тосны экспортын орлогоос Улсын төсөвт 281.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна. Үүнд: 2023 оны 12 сарын 13-ны өдрөөр 4.7 сая баррель буюу 633.7 мянган тонн түүхий тос олборлож, 4.5 сая баррель буюу 612.8 мянган тонныг экспортолсон байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны үйл ажиллагаа, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний нэгтгэсэн тайланд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, Салбарын нийгэм, эдийн засгийн үзүүлэлт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, Байгууллагын ил тод байдлын үнэлгээнд тулгуурлан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу үнэлэхэд байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн биелэлт **87.4%**-тай, ерөнхий үнэлгээг **4.4** оноогоор үнэлэв.

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	88.9	0.6	4.4
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	69.5		
	3. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	69.5		
	4. Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	93.0		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	92.9	0.2	
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100.0		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	97.9	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	-		
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		
Ерөнхий үнэлгээ:		87.4	1.0	

Б. ЗӨВЛӨМЖ

Бодлогын зорилтын хэрэгжилтийн талаар:

- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар нийт 16 зорилтын 75 арга хэмжээ, үүнээс 55 арга хэмжээг яам толгойлон, 20 арга хэмжээг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан. Хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад хүндрэлтэй, тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагад ханддаггүй зэрэг асуудал гарч байгааг анхаарч толгойлон хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах талаар яамны бодлогын газрууд санаачилгатай ажиллах;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг гаргахдаа зорилтот түвшин, хүрсэн түвшин, тухайн арга хэмжээтэй холбоотой гарсан шийдвэрийн талаар оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах;
- Хууль тогтоомжийн биелэлтэд тухайн шийдвэр заалтыг хэрэгжүүлсэн ажил, авсан арга хэмжээний талаар товч, тодорхой биелэлт гаргах, холбогдох тушаал шийдвэрийн огноо дугаар, агуулгыг дурдах, бүрэн хэрэгжсэн гэж үзвэл уг шийдвэр заалтыг хяналтаас хасуулах саналын хамт гаргаж хэвших;
- Төрийн захиргааны удирдлагын газраас тогтоол шийдвэр хяналтад авагдсан тухай бүр тэдгээрийг бүх албан хаагчдад шуурхай хүргэж хэвших шаардлагатай байна.

Байгууллагын чиг үүргийн талаар:

- Яамны тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн жилд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт /тоо хэмжээ, хугацаа, чанар/-ийг оновчтой төлөвлөх;
- Ажил үйлчилгээний биелэлтийг бичмэл хэлбэрээс гадна зураг, дүрс, график ашиглан тайлагнахад анхаарах шаардлагатай.

Байгууллагын нээлттэй байдлын талаар:

- Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг ерөнхий агуулгатай гаргаж байгааг анхаарч ажиллах;
- Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудсыг ашиглахад ойлгомжтой, хялбар болгож хөгжүүлэх тухайлбал Ил тод байдал, Нээлттэй мэдээлэл цэс дэх мэдээллүүдийг тодорхой болгох, давхардлыг арилгах шаардлагатай.

7. ХАВСРАЛТ

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах үйл ажиллагааны биелэлт;
- Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлт;
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;
- Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг биелэлт

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГА

Т.БААСАНПҮРЭВ

НЭГТГЭН БОЛОВСРУУДСАН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ

И.БАТТУЯА

ХШУ ХИЙЖ, ТАЙЛАН
БОЛОВСРУУЛСАН:

ШИНЖЭЭЧ

Д.БАТНАЙРАМДАЛ

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

МЭРГЭЖИЛТЭН

Ж.ЭНХСАЙХАН
Л.МӨНХГЭРЭЛ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтаар төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан.

Тус журмын 6 дугаар хэсэг “Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл, арга зүй”-д нийцүүлэн хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх 3 зорилтын 8 үйл ажиллагаа, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 4 зорилтын 6 үйл ажиллагаа, нийт 14 шалгуур үзүүлэлтийн биелэлтэд үнэлгээг өгөв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр яамны Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг **100%**-тай дүгнэв.

Яамны 2023 оны төсөвт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах, шаардлагатай техник хэрэгслийг шинэчлэх, зэрэг дэв, цалингийн шатлал ахиулах, хоол унааны нэмэгдлийн төсвийг батлуулж хэрэгжүүлсэн байна.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хэрэгжилт /хувь/
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх			
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	<p>Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургууль, Мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан 7 сэдвээр богино хугацааны сургалтад давхардсан тоогоор нийтдээ 35 албан хаагчийг хамруулан сертификат авчээ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт-5 2.Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт-6 3.Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт-6 4.Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалт-7 5.Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт-8 6.Төрийн албан дахь харилцаа, маркетинг богино хугацааны зайн сургалт-1 7.Төсвийн хөрөнгө оруулалт, үр ашгийн болон эрсдэлийн шинжилгээ сургалт-2 	100

2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2023 онд нийт 2 албан хаагч магистрын зэрэг хамгаалахаар гадаад улсад суралцагч талын зардлаар суралцаж байна. Үүнд: Австрали улсад магистрт 1 албан хаагч, Япон улсын Засгийн газраас хэрэгжүүлдэг Монгол Улсын төрийн албаны хүний нөөцийг дэмжих JDS тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэж тус улсын Кюүшүгийн их сургуулийн хуулийн магистрын хөтөлбөрт 1 албан хаагч тус тус суралцаж байна.	100
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	1. Гамшгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-т заасан гамшгийн өмнөх үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тулгуурлахаар заасан бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нийт албан хаагчдад Гамшгийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасанчлан сургаж дадлагажуулахаар гамшгаас хамгаалах сургалтыг, Авлигаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны эсрэг гэмт хэргийн өнөөгийн байдал сэдвээр Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан. Авлигын эсрэг сургалтад яамны албан хаагчдыг хамруулан холбогдох мэдээллийг өгч нийт 57 албан тушаалтан сургалтад хамрагдсан. Мэдээлэл хариуцагчийн зардлаар 2023 онд Геологийн бодлогын газрын ахлах шинжээч Х.Баярхангай МУИС-Байгалийн Шинжлэх Ухааны Сургуульд докторын зэргээр суралцсан. Сургалтын төлбөр 2.9 сая төгрөг. 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2023 онд Нийслэлийн засаг даргын тамгын газарт 2, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 1, Ашигт малтмал газрын тосны газарт 2 албан хаагч шилжин ажилласан бөгөөд тус яаманд Ашигт малтмал, газрын тосны газраас 3 албан хаагч тус тус шилжүүлэн авч ажиллаж байна.	100
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах			
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8 дугаар хэсгийн 8.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн нийт албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг 4 удаа, нийт 368.3 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.	100
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	Албан хаагчдын ажлын байранд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан. Үүнд: 1. Ажлын байрны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд Засгийн газрын байрнуудын нийтлэг үйлчилгээний газраар байрны сантехникийг шалгуулах, цахилгааны холболт, өрөөний цоож, хаалга засварлуулах, байрны цэвэрлэгээ үйлчилгээнд анхаарч ажилласан.	100

2. УУХҮЯ-ны барилгын дээврийн засварын ажил, дотор заслын ажлуудыг гүйцэтгүүлсэн. Дээврийн ажилд 177.6 сая төгрөг, дотор заслын ажилд үүдний хэсгийн засал, шатны хэсэг, коридор, албан хаагчдын өрөө тасалгаа болон жендерийн өрөөг засварлаж тохижуулах ажилд 199.0 сая төгрөг зарцуулсан.

3. Мэдээллийн технологийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж 50.8 сая төгрөг, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж шинэчлэхэд зориулж 19.8 сая төгрөгийг зарцуулсан.

6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад зориулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны төсөвт 26.7 сая төгрөгийн төсвийг батлуулсан. Яамны нийт 89 албан хаагчдыг Улаанбаатар Сөүл сэниорс товер ХХК-ны Улаанбаатар-Сонгодо эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад зориулан 26.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан.	100
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2023 онд нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлаас 66.2 сая төгрөгийг албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад зарцуулсан байна. Улаанбаатар хотын захиргаанд яамны 86 албан хаагчдад зуслангийн газар олгуулах хүсэлтийг тавьсан ба 2023 оны эхний улиралд шийдвэрлэн газар олголт хийгдсэн.	100
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ			100

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

д/д	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	-	37	
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	-	12	
			Мэргэшүүлэх сургалт	-	21	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-	
			Бусад	-	4	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	128 давхардсан тоогоор	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	38	

			Эрэгтэй албан хаагч	-	90	
			Удирдах албан тушаалтан	-	16	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	112	
		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	104.5 хувь	
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	-	Төсвийн хэмнэлтийн хуулийн дагуу гадаад сургалт байхгүй болно.
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	-	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	-	
			Эрэгтэй албан хаагч	-	-	
			Удирдах албан тушаалтан	-	-	
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	2.2 хувь	
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	10.0	2.9	
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	3.3 хувь	
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь		40.6 хувь	

		4.2	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл /нэг өдөрт/ (мян.төг)	-	20.0	
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	100 хувь	
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	1 удаа	
		6.2	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	100 хувь	
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	66.2	

Дүгнэлт:

Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилтын хүрээнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтаар шинэчлэгдсэн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны биелэлт зорилтот түвшиндээ хүрсэн тул 100 оноогоор үнэлэв.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд:

- Ажиллагсдын цалин хөлс, урамшуулал, ажлын байрны нөхцөл, эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн баталгааг хангах ажил зохих түвшинд хангагдсан тул 100 оноогоор үнэлэв.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2022 оны биелэлтийн үнэлгээний тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу 2023 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/128 дугаар тушаалаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах”, А/130 дугаар тушаалаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн албан хаагчдын мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх” хөтөлбөрүүдийг шинэчлэн тус тус батлуулжээ.

Санал, зөвлөмж:


- Тодорхой зорилт, арга хэмжээний хүрээнд дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн, зарцуулсан хөрөнгийн талаар биелэлтийг бүрэн, тодорхой, оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах;
- “Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт” арга хэмжээнд Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургууль, Мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан мэргэшүүлэх сургалтаас гадна бусад төрийн болон төрийн бус, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр зохион байгуулсан сургалтад оролцсон албан хаагчдыг хамруулах;
- Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажлын тайлан, үр дүнгийн талаар тодорхой биелэлт гаргах;
- Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээг илүү тодорхой болгох;
- Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээг илүү тодорхой болгох.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга



Т.Баасанпүрэв

Үнэлгээ хийж тайлан боловсруулсан:
Ахлах шинжээч



И.Баттуяа /2023.02.27/

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
НАРТАЙ 2023 ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1.4, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 21 аймаг, нийслэлийн засаг дарга нартай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтэд өгсөн үнэлгээг дараах хүснэгтээр харуулав. Ерөнхий үнэлгээ 73.8 хувьтай.

**Аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан хамтран
ажиллах гэрээний үүргийн биелэлтэд өгсөн үнэлгээ**

№	Аймгийн нэр	Засаг даргын нэр	Заалтын тоо	Дүгнэсэн арга хэмжээний биелэлтийн хувь							Биелэлтийн хувь
				100	90	70	50	30	0	-	
1	Архангай	Б.Цэрэннадмид	32	2	8	4	4	3	1	10	67.7
2	Баян-Өлгий	А.Камелият	36	9	12	7	2	4	-	2	79.1
3	Баянхонгор	Д.Мөнхсайхан	31	8	11	4	2	2	-	4	82.6
4	Булган	Б.Ариун-Эрдэнэ	26	3	6	3	1	4	2	7	64.2
5	Говь-Алтай	О.Амгаланбаатар	31	3	11	9	1	2	2	3	72.5
6	Говьсүмбэр	Г.Батсуурь	33	2	12	9	1	2	-	7	77.7
7	Дархан-Уул	Б.Азжаргал	29	14	10	2	1	1	-	1	90.0
8	Дорноговь	О.Батжаргал	39	8	18	5	4	2	-	2	81.9
9	Дорнод	М.Бадамсүрэн	39	6	11	6	9	2	3	2	68.1
10	Дундговь	Ц.Мөнхбат	23	9	9	3	-	-	1	1	87.2
11	Завхан	Г.Өнөрбаяр	31	2	6	6	6	4	2	5	60.8
12	Орхон	С.Батжаргал	32	7	12	8	3	2	-	-	79.4
13	Өвөрхангай	И.Доржсүрэн	36	5	8	7	6	5	3	2	63.5
14	Өмнөговь	Р.Сэддорж	41	16	15	6	1	1	-	2	88.5
15	Сүхбаатар	М.Идэрбат	33	6	8	9	5	1	-	4	76.9
16	Сэлэнгэ	Н.Лхагвадорж	34	7	7	7	6	5	-	2	70.9
17	Төв	Д.Мөнхбаатар	32	6	10	6	5	3	1	1	72.9
18	Увс	Ч.Чимэд	33	3	8	8	7	1	-	6	72.6
19	Ховд	Э.Болормаа	33	4	11	5	4	2	5	2	64.5
20	Хөвсгөл	П.Лхагважав	23	1	3	9	4	-	2	4	63.2
21	Хэнтий	Ц.Чогсомжав	33	6	12	7	3	2	2	1	74.4
22	Улаанбаатар	Х.Нямбаатар	25	5	3	3	4	2	2	6	65.3
Үнэлгээний дүн			705	132	211	133	79	50	26	74	73.8

ДУГНЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд аймаг, нийслэлийн засаг дарга нартай 2023 онд нийт 705 заалт бүхий хамтран ажиллах гэрээ байгуулсан. Үүнээс үр дүнтэй хэрэгжсэн 132,

тодорхой үр дүнд хүрсэн 344, эрчимжүүлэх шаардлагатай 129, үр дүнгүй 26 заалт, хэрэгжээгүй буюу үнэлгээ хийгдээгүй 76 заалт байгаа бөгөөд нийт гэрээний үүргийн биелэлт 73.8 хувийн хэрэгжилттэй дүгнэгдлээ. Гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ хэрэгжээгүй буюу үнэлгээ хийгдээгүй заалтуудыг хасаж тооцсон, мөн аймгуудын гэрээний заалтын тоо харилцан адилгүй байгаа нь хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн бодит бус гарахад нөлөөлж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах нийтлэг зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

1. Гэрээний заалтыг аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулж, тухайн орон нутгийн онцлогийг харгалзан, үр дүнд суурилсан байдлаар боловсруулагүйгээс нийт 705 заалт бүхий гэрээнээс 74 заалт хэрэгжээгүй буюу үнэлэх боломжгүй байна. Тухайлбал, Архангай аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 10, Булган аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 7, Говьсүмбэр аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 7 заалт тус тус хэрэгжээгүй буюу үнэлгээ хийгдээгүй байна.

2. Гэрээний хэрэгжилтийг тогтсон загварын дагуу тайлагнадаггүй, хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг тайлангийн хамт ирүүлдэггүй;

3. Өмнөх онуудын гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, санал зөвлөмжийн дагуу дараа жилийн хамтран ажиллах гэрээний заалтыг боловсруулаагүйгээс ихэнх аймгуудад дараах заалтууд жил дараалан хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- Орон нутагт боловсруулах үйлдвэр байгуулах болон түүнтэй холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хууль, журмын хүрээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;
- Аймаг, орон нутагт салбарыг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж төсөл, арга хэмжээг бодлогын хувьд дэмжих, аливаа хөтөлбөр, томоохон төсөлд урьдчилан санал авч байх.

4. “Хамтран ажиллах”, “дэмжлэг үзүүлэх” гэсэн заалтын хүрээнд хийсэн ажлыг тодорхой бус тайлагнаж байна. Мөн “Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 04, 05, 06 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах”, “ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/114 дугаар тушаалаар батлагдсан Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан (1.4-1.10; 2.1-2.9; 3.1-3.2; 4.1-4.8) холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, биелэлтийг 2023 оны 11 дүгээр сард багтаан ирүүлэх” заалтын хэрэгжилтийг албан даалгавар, зүйл тус бүрээр тайлагнах;

5. Тайлан, мэдээ болон санал хүргүүлэх тодорхой хугацаа заасан дараах заалтуудын хэрэгжилтийг албан бичгийн огноо, дугаарыг бичиж, үнэн зөв тайлагнаагүйгээс үнэлгээ буурч байна. Үүнд:

- Түгээмэл тархацтай ашигт малтмал, барилгын материалын ашиглалт, олборлолтын мэдээ, нөөцийн хөдөлгөөний мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газрын чиглэл хариуцсан нэгжид улирал бүр ирүүлэх;

- Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа боловсруулах үйлдвэрүүдийн ерөнхий мэдээллийг хагас жил тутам буюу тухайн жилийн 07 дугаар болон 12 дугаар сарын эхний хагаст багтаан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлэх;
- Орон нутгийн онцлог, давуу талд тулгуурласан эдийн засаг нийгэмд бодит хувь нэмэр оруулах, боловсруулах үйлдвэр байгуулах боломжийн талаар судалгаанд суурилсан санал боловсруулж, II улиралд багтаан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлэх зэрэг заалтууд болно.

6. Тухайн орон нутагт хэрэгжих боломжгүй заалтыг жил бүр гэрээнд тусгаж байгаа нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэлтэй байна.

7. Гэрээний заалтыг хүрч болохуйц, бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан байдлаар тодорхойлж, хийж гүйцэтгэсэн ажлыг бүрэн гүйцэд тайлагнаж, хүрсэн түвшинг үнэн зөв, бодитой үнэлэх шаардлагатай байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Аймгийн удирдлагууд “Хамтран ажиллах гэрээ”-ний төслийг боловсруулахдаа өмнөх оны гэрээний хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, санал зөвлөмжийн дагуу боловсруулах;
- Гэрээний заалт тус бүрээр хийсэн ажлын үр дүнг товч, тодорхой бичиж, тайлангийн чанар, утга найруулгыг хянаж, нотлох баримт буюу холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгийн огноо, дугаарыг дурдах;
- Тухайн аймагт геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгааг харгалзан хөгжлийн зорилтот хөтөлбөр, үндсэн чиглэл болон төлөвлөгөөтэй уялдуулан, орон нутгийн онцлогт нийцсэн зүйл заалт бүхий “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулах;
- Гэрээний заалтад хамааралгүй биелэлт бичих, заалт давхцах, алдаатай дугаарлах зэрэг зөрчлүүд гарч байгааг анхаарах;
- Аймгууд гэрээний хэрэгжилтийг тогтсон загвараар тайлагнах.

Хянасан:
ХШУДАГ-ын дарга

Т.Баасанпүрэв

Үнэлгээ хийж, тайлан боловсруулсан:

ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

Ж.Энхсайхан

Ж.Энхсайхан

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН БАГЦ БОЛОН ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУДЫН 2023 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 02 дугаар сарын 12-ны өдөр

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны худалдан авах ажиллагаа 2023 оны жилийн эцсийн байдлаар 3,762,424.20 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төрлийн худалдан авалтад 3,738,161.35 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 24,262.8 мянган төгрөгийг хэмнэж зарцуулсан байна. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг гаргахад **94.6** оноогоор үнэлэгдэв.

Ерөнхий зүйл

1. Нээлттэй тендер шалгаруулалтаар:
 - Урсгал засвар- 2 багцтай
 - Эрдэм шинжилгээ, судалгааны ажил-1 зөвлөх үйлчилгээний хосолмол үнэлгээний аргаар 1 багцыг
 - Эрдэм шинжилгээ, судалгааны ажил-2 зөвлөх үйлчилгээний чанарын үнэлгээний аргаар 2 багцыг
 - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2022 оны нэгтгэл тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээний хосолмол үнэлгээний аргаар 1 багцыг
2. Тендер шалгаруулалтын онцгой журам “Харьцуулалтын арга”-аар:
 - Мэдээллийн технологийн үйлчилгээг
3. Шууд худалдан авалт:
 - 13 төрлийн худалдан авалт хийсэн. Үүнээс цахим худалдан авалт /ерөнхий гэрээ/-аар 6 бараа, ажил, үйлчилгээг авсан.
4. Худалдан авах ажиллагааны явцад тендерийн хүчинтэй хугацаанд тендерт оролцогчоос гомдол гараагүй.
5. Урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авах 14, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 3, төсвийн хэмнэлтээс 1 төсөл, арга хэмжээг тус тус сонгон шалгаруулсан байна.

Худалдан авах ажиллагааны цахим систем ашигласан талаар

Худалдан авалтыг 100 хувь цахим системээр зохион байгуулж ажилласан бөгөөд цахим худалдан авалт /ерөнхий гэрээ/-аар 6 нэр төрлийн 73.4 сая төгрөгийн өртөгт бүхий бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан. Үүнд: Тендерийн зар

нийтлүүлэх, техник тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн үйлчилгээ багтаж байна.

Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар

Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт **93.0** хувиар, Үндэсний геологийн албаны 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт **94.3** хувиар тус тус үнэлэгдлээ.

Дүгнэлт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны багцын худалдан авах ажиллагааны тайланг Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу үнэлэхэд худалдан авах ажиллагаа “тодорхой үр дүнд хүрсэн” буюу **94.6** хувийн биелэлттэй байна.

Санал, зөвлөмж

1. Худалдан авах ажиллагааг үнэн зөв бодитой төлөвлөх. Зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй, хэрэгжих боломжгүй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх;
2. Төлөвлөсөн хугацаанд худалдан авалтыг зохион байгуулж ажиллах;
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасан босго үнийг баримтлах
4. Цахим дэлгүүрээс худалдан авалтыг хийх;
5. Гэрээний хэрэгжилтийн явцад хяналт тавих, гэрээнд заасан хугацаанд бараа, ажил үйлчилгээг хүлээн авах ажлыг зохион байгуулах, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох;
6. Байгууллагын албан хаагчдыг нэмж худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх.

Хянасан: ХШҮДАГ-ын дарга

Т.Баасанпүрэв

Тайлан бичсэн:

ХШҮДАГ-ын ахлах шинжээч

И.Баттуяа

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2023 оны жилийн эцэс/**

2023 оны 02 дугаар сарын 22-ны өдөр

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд геологийн зураглал, голлох эрдэс түүхий эдийн олборлолт, экспорт, газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 6 ангиллын 18 үзүүлэлтээр дүгнэхэд тайлант хугацаанд 7 үзүүлэлт зорилтот түвшинд хүрсэн буюу давж биелсэн бол үлдсэн 11 үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй, үзүүлэлт буурсан гүйцэтгэлтэй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар “тодорхой үр дүнд хүрсэн” буюу **93.0** хувьтай, **4.7** оноогоор дүгнэгдлээ.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ	
			2020	2023	2023	Хувь	Оноо
1	Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн 1:50 000-ын масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдалт (хувь)	хувь	41.1	46.0	44.0	95.7%	4.9
2	Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн 1:200000-ын масштабын иж бүрэн зураг нэгтгэх төслийн хэрэгжилт (бүх нутгийг хамарсан байх)	хувь	30.0	100.0	100.0	100.0%	5.0
3	Голлох эрдэс түүхий эдийн олборлолтын хэмжээ						
	Газрын тос (мян.бар)	бар	4,199.1	5 982.7	4,888.9	81.7%	4.1
	Нүүрс (сая тн)	сая тн	38.0	71.0	83.2	117.2%	5.0
	Зэсийн баяжмал (мян.тн)	мян.тн	1,270.0	2188.0	1,395.3	63.8%	3.2
	Төмрийн хүдэр (сая тн)	сая тн	8.2	9.5	5.3	56.1%	2.8
	Алт (тн)	тн	19.0	23.0	14.9	64.6%	3.2
4	Голлох эрдэс түүхий эдийн экспортын хэмжээ						
	Газрын тос (мян.бар)	бар	4,198.8	5 922.9	4,730.4	79.9%	4.0
	Нүүрс (сая тн)	сая тн	25.0	45.0	69.6	154.7%	5.0
	Зэсийн баяжмал (мян.тн)	мян.тн	1,270.0	2188.0	1,524.8	69.7%	3.5
	Төмрийн хүдэр (сая тн)	сая тн	8.2	9.5	5.7	60.1%	3.0
	Алт (тн) Монгол банканд тушаасан	тн	19.0	23.0	11.7	51.0%	2.6

5	Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ						
	Үүнээс: ОХУ-аас	сая тн	1.9	2.2	2.2	98.4%	4.9
	Бусад улсаас	сая тн	0.1	0.1	0.1	100.0%	5.0
6	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл (тн)						
	Катодын зэс 99%	тн	9,300.0	9,300.0	9,661.3	101.4%	5.0
	Цахилгааны утас	тн	72.0	80.0	70.2	87.8%	4.4
	Метал бэлдэц	тн	15,507.0	35,350.0	37,680.5	106.6%	5.0
	Метал цувимал	тн	16,675.0	33,000.0	36,117.9	109.4%	5.0
УУХҮЯ-ны ЭЗНХҮ-ийн биелэлтийн ерөнхий үнэлгээ						93.0%	4.7

Тайлангийн хугацаанд буюу 2023 оны 4 дүгээр улиралд БНХАУ-аас нүүрсний импортын татварыг 0 хувьтай болгосонтой холбоотойгоор манай улсын нүүрсний экспортын хэмжээ нэмэгдэж 154.7 хувийн биелэлттэй гарсан байна.

Газрын тосны олборлолт 81.7 хувь, экспорт 79.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь орон нутгийн эсэргүүцэл, Бүтээгдэхүүн хуваах гэрээний тогтворгүй байдлаас шалтгаалан хөрөнгө оруулагч тал олборлолтын хэмжээг бууруулсан байна.

Эдийн засгийн бусад үзүүлэлтүүд 51.0-154.7 хувийн биелэлттэй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 93.0 хувьтай, 4.7 оноогоор дүгнэгдлээ.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга

Т.Баасанпүрэв

Танилцуулга боловсруулсан:
ХШҮДАГ-ын ахлах шинжээч

И.Баттуяа /2024.02.22/

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙН 2023 ОНЫ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН.

2024 оны 02 сарын 23-ны өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж өгөх замаар яамны ил тод, нээлттэй, шуурхай зарчмыг хангаж, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, улмаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон яамны удирдлагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хууль, Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоол, 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэс болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтаар чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 10, хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 6, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 15, үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 2, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 13 нийт 46 үзүүлэлтээр биелэлтийг гаргуулж үнэлгээг өгөв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр нийт шалгуур үзүүлэлтүүдийг **97.9** хувийн биелэлттэй дүгнэв.

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

2023 оны жилийн эцэс

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хэрэгжилт /хувь/
Нэг. Чиг үүрэг үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1	1.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар байршуулан цаг тухай бүрт нь тогтмол шинэчилж, баяжуулалтыг хөтлөн явуулж байна.	100

	хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;		
2	1.2. Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны https://mmhi.gov.mn/ цахим хаяг болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам гэсэн нийгмийн сүлжээний хаягаар үйл ажиллагаагаа иргэд, олон нийтэд сурталчлан таниулж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны www.mmhi.gov.mn вэб хуудсаар яамны ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, мэйл хаяг утасны дугаарыг нээлттэй оруулсан.	90
3	1.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, байгууллагын үйл ажиллагааны нэгдсэн тайланг байгууллагын цахим хуудсанд 2015-2023 он дуустал ИЛ ТОД БАЙДАЛ хэсэгт байршуулж хэвшсэн. Уул уурхайн салбар Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний 27 хувь, экспортын орлогын 92 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 71 хувь, төсвийн орлогын 32 гаруй хувийг бүрдүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 77 хувь уул уурхайн салбарт орсон байна. Түүнчлэн үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импорт, улсын төсвийн орлого болон биет хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг мэдээллийг боловсруулж сар бүр www.mmhi.gov.mn цахим хуудас болон www.opendata.gov.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, хүртээмжтэйгээр хүргэж байна.	90
4	1.4. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалтын хэрэгжилтийг сар бүр яамны газар, хэлтэс болон харъяа агентлагаас хүлээн авч нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д хэрэгжилт, үнэлгээг байршуулж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны www.mmhi.gov.mn вэб хуудасны Ил тод байдал цэсний Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэсэгт тогтмол Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг хагас жил болон жилийн эцсийн байдлаар нээлттэй байршуулсан.	100
5	1.5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд тусгагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт, дунд, богино хугацааны баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хийж, байгууллагын цахим хуудсанд ИЛ ТОД БАЙДАЛ хэсгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ хэсэгт байруулсан. Үүнд:	100
		✓ Алсын хараа-2050 /2 жил тутамд үнэлдэг тул 2023 онд хийгдээгүй/	

		<ul style="list-style-type: none"> ✓ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл ✓ ЗГҮАХ-ийн хэрэгжилтийн үнэлгээ ✓ Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ <p>Аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийн үнэлгээг тус тус байршуулсан.</p>	
6	1.6. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	<p>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актудыг байгууллагын цахим хуудас /mmhi.gov.mn/-ны хууль тогтоомж хэсэгт байршуулсан.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн А/294 дүгээр тушаалаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилийн явц, үр дүнгийн тайлан, цаашид аах арга хэмжээний талаар санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн тайланг удирдлагуудад танилцуулж, 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 03/2459 дугаар албан бичгээр ХЗДХЯ-д хүргүүлсэн.</p>	90
7	1.7. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны www.mmhi.gov.mn вэб хуудсаар яамны ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, мэйл хаяг утасны дугаарыг нээлттэй оруулсан.</p>	100
8	1.8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны www.mmhi.gov.mn вэб хуудсны НЭЭЛЛТЭЙ МЭДЭЭЛЭЛ цэсний “8.2 Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал” хэсэгт байршуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын дагуу УУХҮЯ, АМГТГ, УГА-нд 2023 онд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэж, улирал бүр тайлан мэдээг ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан. /Нийт ирсэн өргөдөл гомдол, санал, хүсэлт, мэдээлэл-688, шийдвэрлэсэн-687, хяналтанд байгаа-1/ Шийдвэрлэлт 99.9% байна.</p>	100
9	1.9. Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	<p>Уул уурхай, хүнд үйлдвэр яам нь аж үйлдвэрийн салбар (уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн)-ын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импорт, улсын төсвийн орлого болон биет хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг мэдээллийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулан боловсруулж сар бүр www.mmhi.gov.mn цахим хуудас болон www.opendata.gov.mn цахим хуудсаар, мөн Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-аас Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн статистик мэдээ, Геологийн статистик мэдээ, Уул уурхайн статистик мэдээ, Газрын тосны статистик мэдээ, Хүнд үйлдвэрийн статистик мэдээ, АМГТГ-аас улсын төсвийн төвлөрүүлэх орлого болон төвлөрүүлсэн орлогын мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар боловсруулж сар бүр www.mrpm.gov.mn цахим хуудас болон www.opendata.gov.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, хүртээмжтэйгээр хүргэж байна.</p>	100
10	1.10. Мэдээлэл хариуцагчаас зохион	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг өөрийн вэб сайт, фэйсбүүк</p>	100

	байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр;	<p>хуудсаар олон нийтэд хүргэдэг ба өнгөрөгч 2023 онд дээрх хоёр сувгаар нийт 160 орчим мэдээлэл нийтэд ил тод, мэдээлэгдсэн байна. Үүнд: уулзалт, арга хэмжээ, хурлын 150 гаруй мэдээлэл, 7 хоног тутмын салбарын статистик мэдээлэл, сар тутмын статистик мэдээллийг хураангуйлж, яамны газар, хэлтсүүдээс ирүүлсэн хурал, уулзалт, хэлэлцүүлгийн зар мэдээ, журам, хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалд санал авах мэдээлэл, бусад зарлалын мэдээлэл багтаж байна</p> <p>Олон нийтийн арга хэмжээний мэдээллүүд сайтын мэдээ мэдээлэл цэс болон сошиал хуудсаар тухай бүрд орж шинэчлэгддэг.</p> <p>https://mmhi.gov.mn/засгийн-газрын-үйл-ажиллагааны-хөтөл/ Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. https://mmhi.gov.mn/ сайтны Мэдээ, мэдээлэл цэсний https://mmhi.gov.mn/мэдээ-мэдээллүүд/ https://mmhi.gov.mn/ярилцлага/ https://mmhi.gov.mn/хэлэлцүүлэг/ https://mmhi.gov.mn/сугралт-2/ https://mmhi.gov.mn/imarc/ https://mmhi.gov.mn/wp-content/uploads/2022/10/IMARC1-2.pdf https://mmhi.gov.mn/2022/12/26/ашигт-малтмалын-баялаг-ордын-нөөцийн-2/</p>	
		Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	
11	2.1. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, харьяа агентлагийн ажлын байрны сул орон тооны зарлалыг яамны вэб хуудас болон Төрийн албаны зөвлөлийн вэб хуудсанд тухай бүр байршуулан ажиллаж байна.	100
12	2.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх сонгон шалгаруулах журмын дагуу сул орон тооны тусгай шалгалтыг тухай бүр нь зохион байгуулж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны вэб хуудсанд мэдээлэл тухай бүр орж байгаа болно.	90
13	2.3. Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэлд Төрийн албаны тухай хууль болон 2023 оны 05 дугаар сарын 04-ны өдөр баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.	90
14	2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг үнэлэх журам;	Хүний нөөцийн стратегийг хэрэгжүүлэх чиглэлээр 2023 онд УУХҮЯ-ны төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн яам, агентлагийн хүний нөөцийн чиглэлээр судалгаа хийж стратеги төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж шинэчлэх талаар 2024 оны төлөвлөгөөнд тусгасан болно.	100
15	2.5. Хүний удирдлагын байдлыг чиглэлээр үнэлэх журам;	Яамны ажилтан, албан хаагчдын мэдээлэл болон сул орон тооны мэдээллийг тухай бүр нь яамны вэб сайтад байршуулдаг бөгөөд холбогдох хууль, журмын дагуу тухай бүр сонгон шалгаруулалтыг зарлан сул орон тоог нөхөн	100

	хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	ажиллаж байна. Яамны хүний нөөцийн мэдээллийг www.mmhi.gov.mn вэб хуудсанд газар хэлтэс хариуцсан ажлын чиг үүргийг оруулсан.	
16	2.6. Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу ТНБДаргын 2023.11.16-ны өдрийн А/138 дугаар тушаалаар УУХҮЯ-ны албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг үнэлэх эрх бүхий "Байгууллагын үнэлгээний баг"-ийг байгуулсан. Үнэлгээний баг 2023.12.14-ний өдөр хуралдан УУХҮЯ-ны нийт албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг үнэлж хурлаас гарсан нэгдсэн саналыг ТНБДаргад хүргүүлсэн. Үүний дагуу Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.10, 9.8, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", Сангийн сайдын 2012 оны 238 дугаар тушаалаар баталсан "Төсвийн урамшуулал олгох хувь, хэмжээ, шалгуур үзүүлэлт, түүнийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам", Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар хэсгийн 8.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТНБДаргын 2023.12.18-ны өдрийн А/158 дугаар тушаалаар мөнгөн урамшуулал олгох тухай тушаал батлуулан хэрэгжүүлсэн.	100
	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал		
17	3.1. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Өмнөх 2022 оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг шилэн дансанд байршуулах хуулийн хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.	100
18	3.2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг шилэн дансанд байршуулах хуулийн хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.	90
19	3.3. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шилэн дансанд байршуулах хуулийн хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.	100
20	3.4. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээний мэдээллийг шилэн дансанд сар бүр байршуулан ажилласан.	100
21	3.5. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг шилэн дансанд байршуулах хуулийн хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.	100
22	3.6. Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг шилэн дансанд байршуулах хуулийн хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.	100
23	3.7. Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш зардлаас бусад таван сая, түүнээс дээш	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	100

	<p>төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;</p>	
24	<p>3.8. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн туншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;</p>	100
25	<p>3.9. Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;</p>	100
26	<p>3.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;</p>	100
	<p>шилэн дансанд байршуулах хуулийн хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.</p>	
	<p>Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн туншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг шилэн дансанд байршуулах хуулийн хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.</p>	
	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын байгууллагуудад шилэн дансны хөтлөлт, хэрэгжилтэд сар, улирал, тухай бүр хяналт тавьж ажилласан.</p>	
	<p>Сайдын багцын байгууллагуудын шилэн дансны хэрэгжилт жигдэрсэн. Шилэн дансны 2023 дансны хөтлөлтийг Сангийн яамнаас 96.0 хувиар үнэлсэн.</p> <p>Үндэсний аудитын газарт 2023/08/03-ны өдрийн 1/1895 албан бичгээр “Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн 2019-2020 оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудит”-ын шалгалтын зөвлөмжийн биелэлтийг хүргүүлсэн.</p> <p>Үндэсний аудитын газраас хийсэн Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг гарган 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 03/2291 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p>	
	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;</p>	
	<p>Түүнчлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны www.mmhi.gov.mn вэб хуудсанд төлөвлөгөө, тайлан, тендерийн урилга нийтэлсэн.</p>	

27	3.11. Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтийг байршуулсан.	100
28	3.12. Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	УУХҮСайдын багцын хүрээнд, захиалагч байгууллага болох УУХҮЯ, АМГТГ, ҮГА-ны худалдан авах ажиллагааг зохион байгуулахад тухай бүр шаардлагатай зөвлөгөө, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан.	90
29	3.13. Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Төсвийн хөрөнгөөр 2023 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг бэхжүүлэх төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд 367.1 сая төгрөг батлагдсан. 2023 оны гүйцэтгэлд 348.1 сая төгрөг зарцуулсан. 2023 онд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ батлагдаагүй. Мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулан ажилласан.	90
30	3.14. Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендер шалгаруулалт явагдсан тухай бүр, шилэн дансанд сар бүр байршуулан ил тод байдлыг ханган ажилласан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендер шалгаруулалт явагдсан тухай бүр, шилэн дансанд сар бүр байршуулан ил тод байдлыг ханган ажилласан. УУХҮСайдын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/292 дугаар тушаалаар ЭШСА-ын жагсаалтыг шинэчлэн батлуулсан. Нийт 3,200.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 багц тендер шалгаруулалтыг зарлан, тендерт шалгарсан оролцогчидтой нийт 3,056.8 сая төгрөгийн гэрээ байгуулан судалгааны ажлыг гүйцэтгүүлсэн. Судалгааны ажлын тайлан, үр дүнг актаар хүлээн авч, санхүүжилтийг 2023 оны 12 дугаар сард багтаан олгосон.	100
31	3.15. Хууль тогтоомжид заасан бусад.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу Уул уурхай; хүнд үйлдвэрийн сайдын болон харьяа төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 2023 оны худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулж, Сангийн яаманд 2023.01.15-ны өдрийн 01/92 дугаар албан бичгээр хүргүүлэн тайлагнасан. - Худалдан авах ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээллийг шилэн данс, байгууллагын цахим хуудас болон төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д тухай бүр байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.	100

Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал

4.1. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;

Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 8.11 болон 8.12-д заасныг үндэслэн “төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх”, “үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх” тусгай зөвшөөрлүүдийг Тусгай зөвшөөрлийн цахим систем /www.license.mn/-ээр дамжуулан 5 жилийн хугацаатайгаар олгож, сунгаж байна. Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргахад бүрдүүлэх материалын жагсаалт, улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ, тэмдэгтийн хураамж төлөх дансны мэдээллийг тусгай зөвшөөрлийн цахим систем болон УУХҮЯ-ны цахим хуудасны төрийн үйлчилгээ хэсэгт байршуулсан. Зөвшөөрлийн нэгдсэн санд тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулдаг.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25.1.7 болон 25.1.9-д тус тус заасны дагуу төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэхэд 200,000 төгрөг, үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэхэд 800,000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийг Тусгай зөвшөөрлийн цахим системээс төлбөрийн даалгавар үүсгэн төлүүлж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 8.4, 8.5, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7, 5 дугаар зүйлийн 5.2.2, 7 дугаар зүйл, 9 дүгээр зүйлд тус тус заасны дагуу бүх төрлийн шатахуун болон шатдаг хийг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг www.license.mn цахим системээр дамжуулан олгож байна. Тус яамны www.mmhi.gov.mn цахим хуудас болон тусгай зөвшөөрөл шийдвэрлэлтийн www.license.mn хуудсуудад тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичиг, тусгай зөвшөөрөлтэй ААН, байгууллагын мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулдаг. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25.1.10.6.1, 25.1.10.6.2, 25.1.10.6.3-д тус тус заасны дагуу бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэхэд 50 сая төгрөг, шатдаг хийн түлшний бөөний худалдаа эрхлэх 1 сая төгрөг, 220 гр-550 гр шатдаг хийн бөөний худалдаа эрхлэхэд 100,000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийг www.itax.mta.mn цахим хуудсаар дамжуулан төлбөрийн даалгавар үүсгэж төлж байна.

Тэсэрч, дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасны дагуу Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрлийг 91 аж ахуйн нэгж 105 тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн төлбөр 3.250.000 төгрөг байна.

4.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх

2023 онд Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх ба Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн 16 хүсэлт ирүүлснээс 9 байгууллагад тусгай зөвшөөрөл шинээр олгож, 5 байгууллагад 5 жилийн хугацаатайгаар сунгалт хийж, 2 байгууллагын тусгай зөвшөөрөл шийдвэрлэлтийн шатандаа байна.

2023 онд бүх төрлийн шатахуун импортлох 67, бөөний худалдаа эрхлэх 69, жижиглэнгийн худалдаа эрхлэх 67, шатдаг хий импортлох 9, бөөний худалдаа эрхлэх 9,

мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	тусгай	жижиглэнгийн худалдаа эрхлэх 2 хүсэлтийг тус тус шийдвэрлэж, цахим гэрчилгээг олгосон. 2023 онд газрын тос ашиглах үйл ажиллагаа эрхэлж буй 2 ААН-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан болно. Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу 2023 онд 36 ААН-д 5 жилийн хугацаатай шинэчлэн олгосон.
--	--------	--

Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал

34	5.1. Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны www.mmhi.gov.mn вэб хуудасны Нээлттэй мэдээлэл цэсний "8.6 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал" хэсэгт эрх зүйн актын төсөлд авсан саналыг нээлттэй байршуулсан. Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн мэдээллийн сан үүсгэх, бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам" батлах тухай Сайдын тушаалын төсөлд санал авахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан ёсны вэб /https://mmhi.gov.mn/ сайтад 2023.11.02-ны өдөр байршуулсан. Журмын хэлэлцүүлгийг 2023.11.29-ний өдрийн 14 цагт УУХҮЯ-ны хурлын танхимд хийсэн бөгөөд хэлэлцүүлэгт Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн гишүүд болон "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ, "Багахангай ҮТП" ОНӨТҮГ-ын төлөөллүүд оролцсон. Мөн Барилга хот, байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрчим хүчний яам, Эдийн засаг, хөгжлийн яамдаас бичгээр санал авсан. 2023 онд УУХҮЯ-ны цахим сайтад Газрын тосны салбараас Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлд, Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн компанийн нөөц бүрдүүлэх журамын төсөл, "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн төсөлд, Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага, Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмын төсөл, Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмын нэмэлт өөрчлөлтийн төсөлд зэрэгт олон нийтээс санал авч ажилласан.	100
35	5.2. Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Эзэмшиж байгаа оюуны өмч байхгүй болно.	/-/
36	5.3. Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төвөөс хамтран боловсруулсан "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн хэлэлцүүлэгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хурлын танхимд 2023.01.13-ны өдөр зохион байгуулж, салбарын албан хаагчдыг хэлэлцүүлэгт оролцуулж холбогдох саналыг тусгуулсан. "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн хүрээнд	90

		2023.12.13-ны өдөр Блю Скай зочид буудалд зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцож холбогдох саналыг тусгуулсан.	
37	5.4. Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд өөрийн эзэмшлийн ямар нэгэн барилга байгууламж болон газар байхгүй болно.	/-/
38	5.5. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны www.mmhi.gov.mn вэб хуудасны Нээлттэй мэдээлэл цэсний "8.6 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал" хэсэгт байршуулсан.	100
39	5.6. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны www.mmhi.gov.mn вэб хуудасны Нээлттэй мэдээлэл цэсний "8.6 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал" хэсэгт байршуулсан.	100

40 5.7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;

5.8. Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны www.mmhi.gov.mn вэб хуудасны Нээлттэй мэдээлэл цэсний "8.6 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал" хэсэгт байршуулсан.

ТӨБЗГазрын 2022.05.20-ны өдрийн А 1/999 дугаар албан бичгийн дагуу яамны балансад бүртгэлтэй нийт 4 ширхэг тээврийн хэрэгслээс "Тоёота лексус-570" маркийн 0131 УНУ, 2300 УБЯ улсын дугаартай 2 ширхэг Жип ангиллын машин, "Соната хьондэй-VII" маркийн 0384 УБҮ дугаартай суудлын автомашинуудыг актаар хүлээлгэн өгсөн. 2023 онд хөрөнгийн хөдлөл хийгдээгүй. мэдээллийг шилэн дансанд байршуулсан болно.

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж нь төслийн Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг Байгаль орчны үнэлгээний тухай хуульд заасны дагуу төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ зэрэг баримт бичигт тусгаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж батлуулж, хэрэгжилтийг хангаж байна.

Технологи дамжуулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт "технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно" гэж заасны дагуу "Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлал"-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарын 2022.06.22-ны өдрийн А/135, А/200 дугаар хамтарсан тушаалаар баталж, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэгт заасны дагуу Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд 5874 дугаарт бүртгүүлсэн. Тус журмын хүрээнд БСШУ-ны сайд, УУХҮ-ийн сайд нарын 2023.05.25-ны өдрийн А/235, А/200 дугаар хамтарсан тушаалаар "Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл" байгуулагдан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: "Гэрэлт говь" ҮТП-ийн техник, технологийн түвшний үнэлгээ, "Алтанширээт" ҮТП-ийн техник, технологийн түвшний үнэлгээг тус тус хэлэлцэж 2023.06.27-ны өдрийн ТТҮ-2023-01-01, ТТҮ-2023-01-02 дугаар дүгнэлтээр хүлээн авсан.

Газрын тосны экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь шороон замаар гүйцэтгэдэг байсан нь тоосжилт үүсгэх нөхцлийг бүрдүүлдэг. Уг асуудлыг шийдвэрлэхээр дараахь арга хэмжээг авч хэргжүүлсэн. Үүнд:

Байгальд орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх Байгаль орчинд ээлтэй, нийгмийн үр ашигтай тээвэрлэлтийн нөхцөл бүрдүүлэх зорилгоор Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул 19 дүгээр талбайн үйлдвэрлэлийн баазаас Баянхошуу-Өвдөгийн хилийн боомт чиглэлийн 210,7 км хатуу хучилттай авто замыг 2016 онд бүрэн ашиглалтад оруулсан ба тус замаар гарын тосны экспортын тээвэрлэлт гүйцэтгэж байна.

Тамсаг-21-р талбайгаас Баянхошуу хилийн боомтын зам хүртэл 58,5 км хатуу хучилттай автозамыг шинээр барьж 2023

100

41

100

		онд ашиглалтанд оруулан газрын тосны тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. Ингэснээр хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх тоосжилтийг бууруулж чадсан.	
42	5.9. Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт байхгүй болно.	/-/
43	5.10. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд байхгүй болно.	/-/
44	5.11. Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	УУХҮЯ-наас олгож буй тусгай зөвшөөрлийн мэдээлэл, ЭБМЗ-ийн үйл ажиллагааны мэдээлэл, АМГТГ-аас олгож буй ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл, хайгуулын болон уулын ажлын тайлан, төлөвлөгөөний мэдээлэл, газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээлэл зэргийг ашиглаж буй системүүдээс гарган авч нийтэд нээлттэйгээр мэдээлж байна. (https://mpc.mmhi.gov.mn/ , https://license.mn/ , https://cmcs.mrpam.gov.mn/cmcs)	100
45	5.12. Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургууль, Мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан 7 сэдвээр богино хугацааны сургалтад давхардсан тоогоор нийтдээ 35 албан хаагчийг хамруулан сертификат авчээ. Үүнд: 1. Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт:-5 2. Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт:-6 3. Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт:-6 4. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалт:-7 5. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт-8 6. Төрийн албан дахь харилцаа, маркетинг богино хугацааны зайн сургалт-1 7. Төсвийн хөрөнгө оруулалт, үр ашгийн болон эрсдлийн шинжилгээ сургалт-2 албан хаагчийг сургасан. Мэдээлэл хариуцагчийн зардлаар 2023 онд Геологийн бодлогын газрын ахлах шинжээч Х.Баярхангай МУИС-Байгалийн Шинжлэх Ухааны Сургуульд докторын зэргээр суралцсан. Сургалтын төлбөрт 2.9 сая төгрөг.	100

5.13. Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.

Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд цаг тухай бүр яамны цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

<https://mmhi.gov.mn/>

Сайтны хууль тогтоомж цэс, ил тод байдал цэсэнд байршуулж тогтмол шинэчилдэг.

<https://ngs.gov.mn/legal/>

<https://ngs.gov.mn/il-tod-baidal/>

<https://mrpam.gov.mn/article/45/>

46

100

ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

97.9

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

№	Шалгуур үзүүлэлт	Заалт	Биелэлт, %/					Биелэлт %/
			100	90	70	0	Хугацаа болоогүй	
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	7	3	-	-	-	97.0
2	Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	4	2	-	-	-	96.7
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	12	3	-	-	-	98.0
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	2	-	-	-	-	100.0
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	13	8	1	-	-	4	98.9
Хэрэгжилтийн дундаж		46	33	9	-	-	4	97.9

Дөрөв. Дүгнэлт

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг нээлттэй болгосон тул **97.9** оноогоор үнэлэв.

Тав. Санал, зөвлөмж

- Яамны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийг тогтмол шинэчилж, яамнаас зохион байгуулж хийсэн томоохон ажлыг иргэд олон нийтэд мэдээлэх
- Биелэлтийг тоо баримт, огноотой нотлох баримтын шаардлага хангуулан тайлагнах.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга

Т.Баасанпүрэв

Үнэлгээ хийж тайлан боловсруулсан:

Ахлах шинжээч

И.Баттуяа /2024.02.23/